



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 09 сарын 15 өдөр

Дугаар 358

Улаанбаатар хот

Г Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах  
тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 15 дугаар зүйлийн 15.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэнд, спортын сайдын “Эрх шилжүүлсэн ажил гүйцэтгүүлэх тухай” 2015 оны 8 дугаар сарын 25 – ны өдрийн 327 дугаар тушаалд дор дурдсан нэмэлт, өөрчлөлт оруулсугай.


“2. XYI.1.2.4.3 Яамны харьяа эрүүл мэндийн байгууллагуудын их засвар /Улсын нэгдүгээр төв эмнэлэгийн барилгын сантехникийн засвар / зарцуулалтыг, XYI.1.2.4.8 Улсын гуравдугаар төв эмнэлэгийн дээврийн засварын ажил /Төсөвт өртөг 350,000,000 /Гурван зуун тавин сая/ төгрөг, үүнээс 2015 онд санхүүжих 243,500,000 /Хоёр зуун дөчин гурван сая таван зуун мянган / төгрөгийн шууд гэрээ байгуулах, сунгах, цуцлах, хяналт тавих, санхүүжүүлэх эрхийг Улсын гуравдугаар төв эмнэлэг /Ц.Төмөр-Очир/-т шилжүүлсүгэй” гэж өөрчлөх;

“2.1 Яамны харьяа эрүүл мэндийн байгууллагуудын их засвар /улсын хэмжээнд/ XYI.1.2.4.9 Эрүүл мэнд, спортын яамны засварын ажил /Төсөвт өртөг 150,000,000 /Нэг зуун тавин сая/ төгрөгийн гэрээ байгуулах, сунгах, цуцлах, хяналт тавих, санхүүжүүлэх эрхийг Эрүүл мэнд, спортын яамны төрийн захиргааны удирдлагын газрын дарга /Б.Эрдэнэчимэг/-д даалгасугай” гэсэн заалт нэмэх;

2. Тушаалд нэмэлт өөрчлөлт оруулсантай холбогдуулан хууль тогтоомжинд заасны дагуу хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс /Т.Баярсайхан/-т даалгасугай.

САЙД

Г.ШИЙЛЭГДАМБА



081292